



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөвсгөл Эрчим хүч” ХХК 2021 оны санхүүгийн тайлан, техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/17/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.1 Байгууллагын үйл ажилагаа.....	9
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	10
4. Аудитын тайлан.....	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Дотоод хяналт.....	13
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
4.4 Материаллаг байдал	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
8. Аудитын илрүүлэлт	14
8.1 Залруулсан алдаа	14
8.2 Төлбөрийн акт.....	15
8.3 Албан шаардлага	15
8.4 Зөвлөмж	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч
ХАЦЭХ	Худалдан авсан цахилгаан эрчим хүч
ТВ	Телевиз
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
БОШХ	Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ
ТЗБАХ	Техник Зохион Байгуулалтын арга хэмжээ
ЦДҮС	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ЦДҮС	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 дөвхөр,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.03.16 № 01/264
танай _____-ны № _____-Т

"ХӨВСГӨЛ ЭРЧИМ ХҮЧ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ З.БАДРАЛ
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6 дугаар зүйлийн 8.4, 8.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Хөвсгөл Эрчим хүч" ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад болон бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн "Хөвсгөл Эрчим хүч" ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Коронавируст халдварын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" 211 дугаар тогтоолын 1-д "Айл өрхийн болон дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэхийг ... нарт тус тус даалгасугай" гэж заасан. Мөн МУ-ын Засгийн газрын 2021 оны 207 дугаар тогтоолоор 2021 оны 07 сарын 1-ээс 12 сарын 31-ны дуустал хугацаанд эрчим хүчний цахилгаан, дулааны төлбөрийг Засгийн газраас төлөхөөр шийдвэрлэсэн байна. Монгол Улсын Засгийн газраас иргэд, ААН-ийн ЦЭХ-ний хөнгөлөлтөд нийт 6,132,3 сая төгрөгийг олгосон байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

"Хөвсгөл Эрчим хүч" ХХК нь 2021 онд 55 жилийн ой арга хэмжээнд ажилчдадаа болон үе үеийн ахмад настнууддаа 9.3 сая төгрөгийн гарын бэлгийг шалгуур үзүүлэлтгүй өгсөн байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар

авах арга хэмжээний тухай"-ын 1.3. ..."зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Бусад асуудал

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 02 сарын 05-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг анх баталсан байна. Эрчим хүчний Зохицуулах хорооны 2021 оны 12 сарын 16 өдрийн 631-р тогтоолоор худалдаж авах цахилгааны төлбөрт өөрчлөлт орсонтой холбогдуулан, ТУЗ-ийн 2021 оны 12 сарын 28-ний өдрийн 19-р тогтоолоор эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол оруулж, орлого, зардлыг нийт 117.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	123,241,189.55	262,425,273.20
1.1.2	Дансны авлага	913,839,315.32	1,336,245,128.57
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	116,801,025.42	75,161,480.01
1.1.6	Бараа материал	406,211,753.43	393,795,811.58
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,560,093,283.72	2,067,627,693.36
1.2.1	Үндсэн хөрөнгө	29,845,582,377.29	29,150,925,797.97
1.2.2	Биет бус хөрөнгө	665,093,831.17	655,638,421.43
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	30,510,676,208.46	29,806,564,219.40
1.3	Нийт хөрөнгийн дүн	32,070,769,492.18	31,874,191,912.76
2.1.1.1	Дансны өглөг	1,212,583,574.03	1,415,604,235.18
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	7,323,385.38
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	19,692,041.47	41,524,502.71
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,232,275,615.50	1,464,452,123.27
2.1.2.1	Урт хугацаат зээл	1,008,466,164.46	1,008,466,164.46
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,008,466,164.46	1,008,466,164.46
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,240,741,779.96	2,472,918,287.73
2.3	Өмч	16,800,000,000.00	16,800,000,000.00
2.3.1	-төрийн	16,800,000,000.00	16,800,000,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,831,501,384.55	7,831,501,384.55
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	8,255,808,949.05	8,317,866,421.53
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-3,057,282,621.38	-3,548,094,181.05
2.3.11	Эздийн өмчийн дүн	29,830,027,712.22	29,401,273,625.03
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	32,070,769,492.18	31,874,191,912.76

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	11,262,023,323.36	12,572,822,876.00
2	Борлуулалтын өртөг	10,345,543,005.36	11,867,828,144.60
3	Нийт ашиг (алдагдал)	916,480,318.00	704,994,731.40
5	Хүүний орлого	855,104.06	0.00
8	Бусад орлого	133,692,754.29	137,524,524.05
9	Борлуулалт, маркетингийн зардал	1,084,715,068.13	1,122,465,177.26
10	Ерөнхий ба удирдлагын зардал	87,191,379.59	90,384,542.63
12	Бусад зардал	33,805,108.51	120,481,095.23

18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-154,683,379.88	-490,811,559.67
19	Орлогын татварын зардал	85,510.41	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-154,768,890.29	-490,811,559.67
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-154,768,890.29	-490,811,559.67
24	Орлогын нийт дүн	-154,768,890.29	-490,811,559.67

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	16,800,000,000.0	7,706,310,134.55	5,503,239,475.45	-2,857,605,470.09	27,151,944,139.91
2	Залруулсан үлдэгдэл	16,800,000,000.00	7,706,310,134.55	5,503,239,475.45	-2,857,605,470.09	27,151,944,139.91
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-154,768,890.29	-154,768,890.29
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	125,191,250.00	2,752,569,473.60	0.00	2,877,760,723.60
8	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,255,808,949.05	-3,057,282,621.38	29,830,027,712.22
2	Залруулсан үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,255,808,949.05	-3,057,282,621.38	29,830,027,712.22
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-490,811,559.67	-490,811,559.67
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	62,057,472.48	0.00	62,057,472.48
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	16,800,000,000.00	7,831,501,384.55	8,317,866,421.53	-3,548,094,181.05	29,401,273,625.03

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1	Мөнгөн орлогын дүн	8,874,883,040.08	10,230,427,892.92
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,852,897,771.71	10,197,001,170.43
1.1.6	Бусад мөнгөн орлого	21,985,268.37	33,426,722.49
1.2	Мөнгөн зарлагын дүн	8,744,022,237.24	10,066,830,859.27
1.2.1	Ажиллагчдад төлсөн	889,757,665.53	911,060,057.68
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	430,747,182.77	455,402,618.45
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	458,242,431.00	522,189,110.73
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	1,854,542.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,258,666,561.20	7,477,525,234.07
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	7,803,607.36	0.00

1.2.7	Татварын байгууллагад төлсөн	468,351,934.25	392,365,373.77
1.2.9	Бусад мөнгөн зарлага	230,452,855.13	306,433,922.57
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	130,860,802.84	163,597,033.65
2.1	Мөнгөн орлогын дүн	855,104.06	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	855,104.06	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн	61,411,520.00	24,412,950.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	61,411,520.00	24,412,950.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-60,556,415.94	-24,412,950.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	48,022,198.00	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	48,022,198.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	48,022,198.00	0.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	22,282,188.90	139,184,083.65
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	100,959,000.65	123,241,189.55
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	123,241,189.55	262,425,273.20

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 он		Өөрчлөлт	Биелэлтийн хувь
				Зорилтот түвшин	Биелэлт		
1	Түгээлтэнд авсан цахилгаан	мян.кВтц	58,228.2	62,166.2	69,489.3	7,323.1	111.8
2	Цахилгаан түгээлтийн алдагдал	мян.кВтц	9,848.5	10,257.4	11,560.6	1,303.2	112.7
		%	16.9%	16.5%	16.6%	0.0	100.6
3	Борлуулсан цахилгаан	мян.кВтц	48,379.2	51,908.8	57,932.8	6,024.0	111.6
	ААНБ-ын хэрэглэгчдэд	мян.кВтц	24,813.7	26,307.3	26,776.1	468.8	101.8
	Ахуйн хэрэглэгчдэд	мян.кВтц	23,565.5	25,601.5	31,156.7	5,555.2	121.7
4	Нийт орлого	сая.төг	11,396.6	11,992.5	12,710.3	717.8	106.0
	Борлуулалтын орлого	сая.төг	7,983.4	8,745.2	9,449.6	704.4	108.1
	Үүнд: ААНБайгууллага	сая.төг	4,480.0	4,861.5	4,819.5	(42.0)	99.1
	Ахуйн хэрэглэгч	сая.төг	3,503.5	3,883.7	4,630.1	746.4	119.2
	Түгээх үйлчилгээний орлого	сая.төг	3,278.6	3,123.3	3,123.2	(0.1)	100.0
	Үйл ажиллагааны бусад орлого	сая.төг	134.5	124.0	137.6	13.6	110.9
5	Нийт зардал	сая.төг	11,551.2	12,442.6	13,201.1	758.5	106.1
	БОШХ	сая.төг	3,690.7	3,911.0	3,921.3	10.3	100.3
	ХАЦЭХ-ний өртөг	сая.төг	7,814.4	8,390.4	9,141.2	750.8	108.9
	Үйл ажиллагааны бусад зардал	сая.төг	46.2	141.2	138.6	(2.6)	98.2
6	Үйл ажиллагааны ашиг алдагдал	сая.төг	(243.0)	(432.9)	(489.7)	(56.8)	113.1
7	Үйл ажиллагааны бусад ашиг алдагдал	сая.төг	88.3	(17.2)	(1.1)	16.1	-
8	<u>Нийт ашиг алдагдал</u>	сая.төг	(154.7)	(450.1)	(490.8)	(40.7)	109.0
9	Борлуулалтын дундаж тариф	төг/кВтц	165.0	168.5	163.1	(5.4)	96.8
10	ХАЦЭХ-ний тариф	төг/кВтц	134.2	135.0	131.5	(3.4)	97.5

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

"Хөвсгөл Эрчим хүч" ХХК-ийн зорилго нь хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Цахилгаан эрчим хүчээр зохицуулалттай хангах, түгээх, борлуулах
- ЦДАШ 0.4-35 кВ-ын дэд станцуудын угсралт засварын ажил, туршилт тохируулгын ажил.
- Бусад тохируулгын ажил.
- Компанийн хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа явуулах тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.
- Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний дараа тухайн үйл ажиллагааг явуулна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2002 оны 05 дугаар тогтоолыг үндэслэн "Хөвсгөл Эрчим хүч" ХХК-ийг үүсгэн байгуулагдсан байна. Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 в/-д "тухайн орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөх, татан буулгах санал боловсруулж Хурал, түүний Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг Компанийн тухай хуулийн 78-р зүйлийн 78.1.-д заасны дагуу "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхын саналаар сонгоно", гэж заасан байна.

"Хөвсгөл Эрчим хүч" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дордуулахгүй байхаар буюу ТУЗ-ийн дарга 0.5 сая төгрөг, нарийн бичгийн дарга 0.9 сая төгрөг, гишүүд 0.4 сая төгрөгөөр тогтоосон байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3. "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасан байтал дэд захирлын орон тоог шинээр нэмэгдүүлж, тус компанийн 55 жилийн ой тохиож ажилчдадаа болон үе үеийн ахмад настнууддаа 9.3 сая төгрөгийн гарын бэлэг өгсөн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. "Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн

хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "13.5" хувьд өөрчлөлт орж "12.5" хувь болж өөрчлөгдсөн байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

"Хөвсгөл Эрчим хүч" ХХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2018 онд боловсруулсан бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон хэдий ч шинээр батлагдсан хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая.төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	123.2	262.4	139.2
Авлага	1,030.6	1,411.4	380.7
Урьдчилгаа			
Бараа материал	406.2	393.8	(12.4)
Үндсэн хөрөнгө	29,845.6	29,150.9	(694.7)
Биет бус хөрөнгө	665.1	655.6	(9.5)
Нийт хөрөнгийн дүн	32,070.8	31,874.2	(196.6)
Өр төлбөрийн дүн	2,240.7	2,472.9	232.2
Богино хугацаат өглөг	1,232.3	1,464.5	232.2
Урт хугацаат өглөг	1,008.5	1,008.5	-
Эздийн өмч	29,830.0	29,401.3	(428.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	32,070.8	31,874.2	(196.6)

"Хөвсгөл Эрчим хүч" ХХК-ийн мөнгөн хөрөнгө 262.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Касс дахь бэлэн мөнгөний нийт үлдэгдэл 0.4 сая төгрөг байна. Энэ нь касс-1 буюу хэрэглэгчдэд үйлчлэх төвийн касс-д заавал байх үлдэгдэл 0.3 сая төгрөг, захиргаа аж ахуйн бэлэн мөнгөний кассын нярвын үлдэгдэл 0.1 сая төгрөг байна.
- Банкин дахь мөнгөний үлдэгдэл болох харилцах дансанд байгаа 262.0 сая төгрөг нь Хаан банкин дахь хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний төлбөрийн дансанд 10.1 сая төгрөг, Хаан банкин дахь компанийн зарлагын харилцах дансанд 201.8 сая төгрөг, Голомт банкин дахь хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний төлбөрийн дансанд 1.4 сая төгрөг, Голомт банкин дахь компанийн зарлагын харилцах дансанд 5.1 сая төгрөг, Хас банкин дахь компанийн зарлагын харилцах дансанд 1.9 сая төгрөг, Төрийн банкин дахь компанийн зарлагын харилцах дансанд 41.7 сая төгрөг тус тус байршиж байгаа нь банкны үлдэгдлийн баталгаатай таарч байна.

"Хөвсгөл Эрчим хүч" ХХК-ийн авлагын үлдэгдэл 1,411.4 сая төгрөг байна. Энэ нь ААНОАТ-ын авлага 0.5 сая төгрөг, НӨАТ-ын авлага 74.2 сая төгрөг, НДШ-ийн авлага 0.02 сая төгрөг, ХАОАТ-ын авлага 0.4 сая төгрөг, дотоодын байгууллагаас авах авлага 20.6 сая төгрөг, телевизийн хураамжийн авлага 9.3 сая төгрөг, хэрэглэгчдээс авах цахилгаан эрчим хүчний авлага 301.2 сая төгрөг, шөнийн тарифын хөнгөлөлтийн авлага 148.1 сая төгрөг, хэрэглэгчдийн цахилгааны төлбөрийг төрөөс хариуцсантай холбоотой үүссэн Монгол улсын Засгийн газраас авах цахилгааны авлага 842.8 сая төгрөг байна.

Тайлант онд авлага 380.7 сая төгрөгөөр өссөн нь хэрэглэгчдийн цахилгааны төлбөрийг төрөөс хариуцсантай холбоотой үүссэн Монгол улсын Засгийн газраас авах цахилгааны авлага 566.3 сая төгрөг, шөнийн тарифын хөнгөлөлтийн авлага 102.2 сая төгрөг, аж ахуй нэгж, хэрэглэгчдээс авах цахилгааны авлага, 26.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, айл өрхөөс авах ЦЭХ авлага 133.5 сая төгрөгөөр, телевизийн хураамжийн авлага 2.9 сая төгрөг, дотоодын байгууллагаас авах авлага 11.8 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 393.8 сая төгрөг болж 12.4 сая төгрөгөөр буурсан нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 30 өдрийн 130 дугаар тогтоолоор Мөрөн сумын гэрэлтүүлгийн тохижилт хариуцсан албан хаагчдыг эзэмшиж буй хөрөнгө, бараа материалын хамт Мөрөн сумын Хот тохижилт үйлчилгээний газарт шилжүүлэх тухай шийдвэрийн дагуу гэрэлтүүлгийн материал 7.1 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Тайлант онд худалдан авалтаар 756.8 сая төгрөгийн бараа материал хүлээн авсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй 14.6 сая төгрөгийн 7 нэр төрлийн бараа материал байна. Энэ нь Эрчим хүчний зохицуулах хорооноос тус компанийн материал хангамжийн зардалд батлагдсан дүнгээс илүү бараа материал актлахгүй байх зөвшөөрөл олгодог бөгөөд 2021 онд батлагдсан дүн 3.7 сая төгрөг ажилчдад ашиглагдаж буй картлагдсан бараа материал болох бахь, отвари, амперклейш, дөрөө, бүс гэх мэт материалыг акталж устгасан байна.

Оны эцэст худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 29,150.9 сая төгрөг болж 694.7 сая төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Шинээр 130.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, дуусаагүй барилга, их засварын зардал 137.5 сая төгрөгөөр, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр 76.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авсан, өөрийн хөрөнгөөр 267.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг нэмж байгуулсан байна. аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 30 өдрийн 130 дугаар тогтоолоор Мөрөн сумын гэрэлтүүлгийн тохижилт хариуцсан албан хаагчдыг эзэмшиж буй хөрөнгө, бараа материалын хамт Мөрөн сумын Хот тохижилт үйлчилгээний газарт 16.3 сая төгрөгийн авто краныг шилжүүлж байна. Тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдэл 1,321.1 сая төгрөг байна.

Биет бус хөрөнгийн үлдэгдэл 655.6 сая төгрөг бөгөөд 9.5 сая төгрөгөөр буурсан байгаа нь тайлант хугацааны элэгдлийн зардал байна.

Дуусаагүй барилга данс 237.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл шинэчлэл болон компанийн техник зохион байгуулалтай арга хэмжээний зардлаас хийж байгаа ажлын гүйцэтгэлтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 1,464.5 сая төгрөг байна. Урт хугацаат өр төлбөр дансанд 1,008.5 сая төгрөгийг 2002 онд Сангийн яам, Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн байгуулсан 2007 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн MOG-3503 тоот дамжуулан зээлдүүлэх гэрээний өр төлбөр бөгөөд, жилд үндсэн төлбөрөөс 04 сарын 01-ний өдөр, 10 дугаар сарын 01-ний өдөр жилд 2 удаа хүүгийн төлбөрт 7.3 сая төгрөг төлөхөөр 2021 оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал буюу гарз гэж ангилсан байна.

Хүснэгт 2

Нийт зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөг/

Үзүүлэлт	2021 он		Төлөвлөгөө биелэлт	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биет	Хувь
Үйл ажиллагааны зардал	3,911.0	3,921.3	10.3	100.3
Үйл ажиллагааны бус зардал	141.2	138.6	(2.6)	98.1
Худалдаж авсан ЦЭХ-ний үнэ	8,390.4	9,141.2	750.8	108.9
Нийт зардал	12,442.6	13,201.1	758.5	106.1

Тайлант онд нийт зардал 758.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хэрэглэгчийн цахилгааны төлбөрийг төрөөс хариуцсантай холбоотой цахилгаан эрчим хүчний хэрэглээний огцом өсөлтөөс шалтгаалсан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй. ТУЗ-ийн 2021 оны 04 дүгээр тогтоолоор “Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Үүнд:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн үзүүлэлт

Хүснэгт 3

/сая.төг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 он		Өөрчлөлт	Биелэлтийн хувь
				Зорилтот түвшин	Биелэлт		
1	Түгээлтэнд авсан цахилгаан	мян.кВтц	58,228.2	62,166.2	69,489.3	7,323.1	111.8
2	Цахилгаан түгээлтийн алдагдал	мян.кВтц	9,848.5	10,257.4	11,560.6	1,303.2	112.7
		%	16.9%	16.5%	16.6%	0.0	100.6
3	Борлуулсан цахилгаан	мян.кВтц	48,379.2	51,908.8	57,932.8	6,024.0	111.6
4	Нийт орлого	сая.төг	11,396.6	11,992.5	12,710.3	717.8	106.0
5	Нийт зардал	сая.төг	11,551.2	12,442.6	13,201.1	758.5	106.1
6	<u>Нийт ашиг алдагдал</u>	сая.төг	(154.7)	(450.1)	(490.8)	(40.7)	109.0

Дээрх үзүүлэлтүүдэд нөлөөлсөн хүчин зүйлүүдийг товч тайлбарлан авч үзвэл.

- Тайлант онд 62,166.2 мян.кВт.ц ЦЭХ худалдан авч түгээхээр төлөвлөснөөс ЦДҮС ТӨХК-аас 69,489.3 мян.кВт.ц ЦЭХ худалдан авч түгээн борлуулсан ба ЦЭХ-ний төлөвлөгөө 111.8 хувиар биелүүлсэн байна. Энэ нь хэрэглэгчийн цахилгааны төлбөрийг төрөөс хариуцсантай холбоотой цахилгаан эрчим хүчний хэрэглээний огцом өсөлтөөс шалтгаалсан байна.
- ЭХЗХорооноос 2021 онд түгээлтийн алдагдлыг 16.7%-иар баталж, компанийн ТУЗ нь алдагдлыг 16.5%-иар болгон баталсан байна.
 - o Худалдан авсан цахилгааны 11,560.1 мян.кВт.ц буюу 16.6% нь түгээлтийн алдагдал байна.
- 2021 онд 12710.3 сая төгрөгийн орлого олж 13,201.1 сая төгрөгийн зардал гаргаж 490.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

4. Аудитын тайлан**4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад НББББ, Мэдээллийн технологийн аюулгүй байдал, дотоод хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төгс суурь стандарт аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Батсайхан, чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл нар гүйцэтгэж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар анхан шатанд чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 1/68 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн. Тус байгууллага дотоод хяналтын журам 2019 онд батлагдсан байна. Дотоод хяналтын ажилтан ажлаасаа халагдаж шүүхийн шийдвэрээр эргэн орж өөр ажилд томилогдсон байна. Тайлант онд дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 10,345.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 155.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80-хувиар буюу 124.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т хамаарах орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 3 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл Эрчим хүч ХХК нь тайлант онд нийт 3,809.9 сая төгрөгийн 67 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 67 мэдээллийг ил тод байршуулсан байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаал “автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норматив”-ын дагуу автомашины шатахуун зарцуулалтыг анхан шатны баримтаас түүвэрлэн үзэхэд 0.1 сая төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан байна. Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах гэж заасан жишиг нормативтай нийцэхгүй байна.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаагүй, мөн татварын ТТ11 тайланд 8 ажилтны цалинг 1.5 сая төгрөгөөр дутуу, 6 ажилтны регистрийн дугаарыг зөрүүлж тайлагнасан алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 1.5 сая төгрөгийн алдааг залруулж ажилласан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,249.6 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгснөөс дотоод хяналттай холбоотой зөвлөмж биелээгүй бөгөөд нийт гүйцэтгэл 75 хувийн биелэлттэй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж,
акт, албан шаардлагын хэрэгжилт

Хүснэгт 4.

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	4,249.6	3	4,249.6	1	-	-
Нийт дүн	4	4,249.6	3	4,249.6	1	-	-

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол Улсын Засгийн газраас хэрэглэгчийн цахилгааны төлбөрийг төрөөс хариуцан хөнгөлж байгаа ЦЭХ-ний хэрэглээг журмын дагуу тооцсон эсэхийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.5 сая төгрөгийг дутуу тайлагнасан алдааг залруулж, 9.4 сая төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1.5 сая төгрөгийн 1 алдааг залрууллаа. Үүнд:

Татварын ТТ11 тайланд 8 ажилтны цалинг 1.5 сая төгрөгөөр дутуу, 6 ажилтны регистрийн дугаарыг зөрүүлж тайлагнасан алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 1.5 сая төгрөгийг залруулж ажилласан.

8.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй болно.

8.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. НБББББ-тэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2018 онд боловсруулсан бөгөөд шинээр батлагдсан холбогдох хууль тогтоомжтой нийцэхгүй байна. Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам зааварт нийцүүлэн НБББББ-ийг баталж мөрдөн ажиллана” заалтыг зөрчсөн.

1.2. Өгсөн зөвлөмж:

НБББББ-ийг хууль тогтоомж, стандарт, заавар, журамд нийцүүлэн шинэчилж байх.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1.1 Илрүүлэлт:

Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “*Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй холбоотой мэдээллийг тухайн аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээдийн /гүйцэтгэх удирдлага буюу түүнээс эрх олгосон бусад этгээд/ бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно*” гэж заасантай нийцэхгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж:

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж, хэрэгжүүлж ажиллах.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Монгол Улсын Засгийн газрын 311-р тогтоолоор Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам 3 дугаар зүйлийн 3.4-д заасан 3.4. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.” гэсэн заалтуудтай нийцэхгүй ба үнэлгээ, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаж ажиллаагүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж

Дотоод хяналтын төлөвлөгөө хөтөлбөр гарган гүйцэтгэлийг тайлагнаж, дотоод хяналтын талаарх Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах.

4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаал “автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норматив”-ын дагуу автомашины шатахуун зарцуулалтыг анхан шатны баримтаас түүвэрлэн үзэхэд 0.1 сая төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан байна. Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах гэж заасан жишиг нормативтай нийцэхгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын дагуу шатахуун зарцуулалтын жишиг нормыг мөрдөж ажиллах.

5. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн 2021 онд шинээр албан тушаал нэмж томилгоо хийсэн, ойн арга хэмжээ зохион байгуулж ажилчид болон ахмад настнуудад 9.3 сая төгрөгийн гарын бэлэг өгсөн байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”-ын 1.2. шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх” 1.3. төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс										
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн асуудлаар																	
	Хөвсгөл Эрчим хүч ХХК	ХӨА-2022/17/НА-СТА-ОНА	Татвартай холбоотой	ХХОАТ-ыг дутуу суутгасан	1	1.5	1	1.5									
			НББББ-тэй холбоотой	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр батлагдсан хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчлэн батлуулах	1										1		
			Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалттай холбоотой	Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж, хэрэгжүүлж ажиллах.	1											1	
			Дотоод хяналттай холбоотой асуудал	Дотоод хяналтын төлөвлөгөө хөтөлбөр гарган гүйцэтгэлийг тайлагнаж, дотоод хяналтын талаарх Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах.	1											1	
			Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын дагуу шатахуун зарцуулалтын жишиг нормыг өөрийн онцлогт тохируулан журам боловсруулж мөрдөж ажиллах	1	0.1										1	0.1
			Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	1	9.3										1	9.3
НИЙТ ДҮН					6	10.9	1	1.5						5	10.9		

